**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2021 оны 02 сарын 10 өдөр Дугаар А/130 Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн
лабораторийн үйл ажиллагааны
заавраын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. “Нэг хаалга-нэг шинжилгээ” Коронавируст халдвар /КОВИД-19/ илрүүлэх арга хэмжээний хүрээнд “Лабораторийн шинжилгээний чанарын хяналтын үнэлгээг хийхэд лабораториудын хамрагдах хуваарь, шинээр нээгдэж буй молекул биологийн лабораториудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах мэргэжилтний хуваарь”-ийг нэгдүгээр, Молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, доголдол гарсан үед шуурхай ажиллах “Засвар үйлчилгээний баг”-ийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д үүрэг болгосугай.

САЙД С.ЭНХБОЛД

21-Tushaal-A

14121031

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 сарын 10 өдрийн А/50 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19) ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ БУЙ ЛАБОРАТОРИУДЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

Коронавируст халдвар /КОВИД-19/ илрүүлэх шинжилгээ хийж буй лабораториудын чанарын үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2021 оны Коронавируст халдвар /КОВИД-19/ илрүүлэх шинжилгээний лавлах, баталгаажуулах, чанарын үнэлгээ хийх, мэдээлэх А/49 дүгээр түр зааврын зарчмын дагуу үнэлнэ.

### Нэг хаалга, нэг шинжилгээ” коронавируст халдварын өргөжүүлсэн тандалтын үеэр лабораторийн шинжилгээний чанарын хяналтын үнэлгээнд хамрагдах хуваарь

| № | Байгууллагын нэр | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ХӨСҮТ-ийн гепатит, энтеровирусийн лаборатори | | | | | | | | | | | √ | |
| 2 | ХӨСҮТ-ийн БЗДХӨ-ийн лаборатори | | | | | | | | | | √ | | |
| 3 | ЗӨСҮТ-ийн молекул биологийн лаборатори | | | | | | | | | √ | | | |
| 4 | НЭМҮТ-ийн молекул биологийн лаборатори | | | | | | | | √ | | | | |
| 5 | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн молекул биологийн лаборатори | | | | | | √ | | | | | | |
| 6 | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн молекул биологийн лаборатори | | | √ | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | биологийн лаборатори | | | | | | | | | | | | |
| 7 | Баянгол дүүргийн молекул биологийн лаборатори | | | | | √ | | | | | | | |
| 8 | Сонгино хайрхан дүүргийн молекул биологийн лаборатори | | | | √ | | | | | | | | |
| 9 | БЗД-ийн молекул биологийн лаборатори | | | √ | | | | | | | | | |
| 10 | СБД-ийн молекул биологийн лаборатори | | | √ | | | | | | | | | |
| 11 | ХУД-ийн молекул биологийн лаборатори | √ | | | | | | | | | | | |
| 12 | ЧД молекул биологийн лаборатори | √ | | | | | | | | | | | |
| 13 | “Гялс” молекул биологийн лаборатори | | | | √ | | | | | | | | |

- Чанарын үнэлгээг Эрүүл мэндийн яамны Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/577 дугаар тушаалаар батладсан ажлын хэсгийн гишүүд үнэлнэ.
- Үнэлгээ хийсэн гишүүд тухайн өдрийн 18.00 цагт Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлнэ.
- Үнэлгээ хийсний дараагаар нэгдсэн тайлангийн хурлыг 2021.02.24-ний өдөр хийнэ.
- Ажлын хэсгийн тайлангийн дагуу хариуцсан албан тушаалтан дор бүр нь тулгарсан асуудлыг шийдвэрлэж, мэргэжил арга зүйгээр хангана.

Нэг хаалга, нэг шинжилгээ" коронавируст халдварын өргөжүүлсэн тандалтын үеэр лабораторийн шинжилгээний чанарын хяналтын үнэлгээнд хамрагдах хуваарь

| № | **ХӨСҮТ-ийн вирус судлалын лаборатори баталгаажуулна.** | **Баталгаажуулах шинжилгээ хийнэ:** "Эерэг" хариу гарсан сорьцоо баталгаажуулах шинжилгээнд илгээнэ | **Давтан шинжилгээ хийж үнэлэх:** "сөрөг" хариу гарсан сорьцийн 10 ширхэгийг ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторит баталгаажуулах | **Чанарын хяналтын сорьц илгээж үнэлгээ зохион байгуулах:** Чанарын хяналт, үнэлгээний багц авч шинжлэх -Халдвар, хяналтын үнэлгээнд хамрагдах |
|---|---|---|---|---|
| 1 | ХӨСҮТ-ийн гепатит, энтеровирусийн лаборатори | √ | 2021.02.11, 2021.02.15, 2021.02.19 | 2021.02.15 |
| 2 | ХӨСҮТ-ийн БЗДХӨ-ийн лаборатори | √ | 2021.02.12, 2021.02.16, 2021.02.20 | 2021.02.15 |
| 3 | ЗӨСҮТ-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.14, 2021.02.18, 2021.02.22 | 2021.02.15 |
| 4 | НЭМҮТ-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.11, 2021.02.15, 2021.02.19 | 2021.02.14 |
| 5 | УНТЭ-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.12, 2021.02.16, 2021.02.20 | 2021.02.14 |
| 6 | УХТЭ-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.14, 2021.02.18, 2021.02.22 | 2021.02.14 |
| 7 | БГД-ын молекул биологийн лаборатори | √ | 2021.02.11, 2021.02.15, 2021.02.19 | 2021.02.13 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | СХД-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.12, 2021.02.16, 2021.02.20 | 2021.02.13 |
| 9 | БЗД-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.14, 2021.02.18, 2021.02.22 | 2021.02.13 |
| 10 | СБД-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.11, 2021.02.15, 2021.02.19 | 2021.02.12 |
| 11 | ХУД-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.12, 2021.02.16, 2021.02.20 | 2021.02.12 |
| 12 | ЧД-ийн молекул биологийн лаборатори | √ | 2021.02.14, 2021.02.18, 2021.02.22 | 2021.02.12 |
| 13 | “Гялс” молекул биологийн лаборатори | √ | 2021.02.14, 2021.02.18, 2021.02.22 | 2021.02.11 |

## ШИНЭЭР НЭЭГДЭЖ БУЙ МОЛЕКУЛ БИОЛОГИЙН ЛАБОРАТОРИУДАД МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВӨЛГӨӨ ӨГЧ АЖИЛЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ ХУВААРЬ

| № | Байгууллагын нэр | Мэргэжил арга зүйгээр хангах мэргэжилтний нэр | Албан тушаал, утасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | УНТЭ-ийн молекул биологийн лаборатори | Ц.Наранзул | Вирус судлалын лаборатори, вирус судлаач, 96822555 |
| 2 | УХТЭ-ийн молекул биологийн лаборатори | Н.Баясгалан | Вирус судлалын лаборатори, вирус судлаач, 99613388 |
| 3 | БГД-ийн молекул биологийн лаборатори | Г.Сарангуа | Хепатит Энтеровирусийн лабораторийн эрхлэгч, 99145810 |
| 4 | СХД-ийн молекул биологийн лаборатори | Б.Сайханхүү | Нэгдсэн лабораторийн албаны үйл ажиллагааны менежер |
| 5 | БЗД-ийн молекул биологийн лаборатори | Э.Алтансүх | Хепатит Энтеровирусийн лабораторийн эрхлэгч |
| 6 | СБД-ийн молекул биологийн лаборатори | Г.Цогзолмаа | Вирус судлалын лаборатори, вирус судлаач, 91116139 |
| 7 | ХУД-ийн молекул биологийн лаборатори | Н.Амарбаясгалан | ДОХ/БЗДХ-ын лабораторийн эмч, 96960455 |
| 8 | ЧД-ийн молекул биологийн лаборатори | Ш.Мягмарсүрэн | ДОХ/БЗДХ-ын лабораторийн эмч, 96960455 |

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 сарын 10 өдрийн А/30 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ, ДОГОЛДОЛ ГАРСАН ҮЕД ШУУРХАЙ АЖИЛЛАХ "ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГ"-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Багийн ахлагч: | Т.Бямбасүрэн, ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| Багийн зохицуулагч: | Б.Сансармаа, ЭМЯ-ны Лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Б.Санж-Очир, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны мэргэжилтэн |
| Багийн гишүүд: | Ц.Отгонжаргал, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн эрхлэгч |
| | Б.Баасанжав, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| | Э.Тунгалагтуяа, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| | С.Учрал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга |
| | Д.Пүрэвдорж, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн эрхлэгч |
| | Д.Нямсүрэн, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| | н.Бат-Эрдэнэ, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| | Ц.Сосорбарам, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| | О.Дарамсэнгэ, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |

Б.Номин, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Ж.Баянбаатар, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

А.Мягмарсүрэн, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

И.Сундуйдэлгэр, “Лайфтроник” ХХК-ий тоног төхөөрөмжийн инженер

Б.Мандалбаяр, “Лайфтроник” ХХК-ий тоног төхөөрөмжийн инженер

Ж.Шарав, “Пролианс” ХХК-ий тоног төхөөрөмжийн инженер

Б.Энхтөр, “Медбуян” ХХК-ий тоног төхөөрөмжийн инженер

Ч.Түвшинтөгс, “Медбуян” ХХК-ий тоног төхөөрөмжийн инженер

# ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГИЙН
# АЖИЛЛАХ УДИРДАМЖ

**Үндэслэл:**

Эрүүл мэндийн салбарт /улсын эмнэлэг/-т нийт 17 байршилд молекул биологийн лаборатори ажиллаж байгаа бөгөөд, 35 PCR аппарат, 25 нуклейн хүчил ялгагч аппараттайгаар ПГУ шинжилгээ хийж байна. Үүнээс Улаанбаатар хотод 11 байршилд 30 PCR аппарат, 27 нуклейн хүчил ялгагч аппарат ажиллаж байна.

**Зорилго:**

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээний үеэр "Молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмж"-ийн хэвийн үйл ажиллагааг хангах, доголдол гарсан үед шуурхай ажиллах

**Хийгдэх үйл ажиллагаа:**

1. "Нэг хаалга - нэг шинжилгээ" арга хэмжээний үеэр хэвийн үйл ажиллагааг хангаж, доголдол гарсан үед зохицуулалт хариуцсан хүмүүс засвар үйлчилгээ хийх мэргэжилтэнг дуудаж ажиллуулна.
2. Засвар үйлчилгээг 2 үе шаттайгаар зохион байгуулна.
    a. Тухайн эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийн хариуцсан инженерийг дуудаж, гэмтлийг тодорхойлж, засвар үйлчилгээг гүйцэтгүүлнэ.
    b. Шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч байгууллагын инженерийг дуудаж, засвар үйлчилгээг гүйцэтгүүлнэ.
3. Засвар үйлчилгээний багийн гишүүд дээр арга хэмжээний үеэр утасаа салгахгүй, бэлэн байдлыг хангаж ажиллана.
4. Тоног төхөөрөмжийн доголдол үүсч, засвар үйлчилгээний мэргэжилтэн дуудан ажиллуулах тохиолдолд мэргэжилтэнг гэрээс нь авах хүргэх, мэргэжилтэнг лабораторид орж ажиллах нөхцөл, хувийн хамгаалах хэрэгслээр хангах үйл ажиллагааг болон тухайн эрүүл мэндийн байгууллага бүрэн хариуцана.
5. Засвар үйлчилгээ гүйцэтгэх мэргэжилтнүүд халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллана.
6. Дуудагдан ажилласан мэргэжилтнүүд тоног төхөөрөмжийн засварын үйлчилгээг гүйцэтгэж, холбогдох эмч, мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
7. Мөн засвар үйлчилгээний тайлан бичих бөгөөд тайланд гэмтлийн шалтгаан, оношилгоо, сольсон болон засварласан сэлбэг хэрэгслийн нэр, тоо ширхэг, үнийг тусгасан байна.

| № | Үйл ажиллагаа | Хариуцах мэргэжилтэн |
|---|---|---|
| 1 | Засвар үйлчилгээний багийн ерөнхий зохицуулалт | Т.Бямбасүрэн |
| 2 | Лавлагаа шатлалын төвүүдийн зохицуулалт | Б.Сансармаа |
| 3 | Дүүргийн эрүүл мэндийн төвийн зохицуулалт | Б.Санж-Очир |
| 4 | Молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмжийн тус бүрийн бэлэн байдлыг шалгаж, тэмдэглэл хөтлөх | 11 эрүүл мэндийн байгууллагын инженерүүд |
| 5 | Лабораторийн тоног төхөөрөмжийн цахилгааны эх үүсвэрээр тасралтгүй хангах, цахилгааны нөөц үүсгэвэр /мотор/ холбох, бэлэн байдлыг шалгах | |
| 6 | "Нэг хаалга - нэг шинжилгээ" арга хэмжээний үеэр доголдол гарсан үед **Нийслэлийн 6 дүүрэг, УНТЭ, УХТЭ**-ийн лабораторийн тоног төхөөрөмжийн үндсэн тоног төхөөрөмж болох PCR болон нуклейн хүчил ялгах аппаратны засвар үйлчилгээ хийж, шуурхай ажиллах | Лайфтроник ХХК-ийн инженер |
| 7 | "Нэг хаалга - нэг шинжилгээ" арга хэмжээний үеэр доголдол гарсан үед **Нийслэлийн 6 дүүрэг**, **УНТЭ, УХТЭ**-ийн лабораторийн тоног төхөөрөмжийн бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийж, шуурхай ажиллах | Антиген ХХК, Медбуян ХХК-ийн инженерүүд |
| 8 | "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээний үеэр доголдол гарсан үед **ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ**-ийн лабораторийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийж, шуурхай ажиллах | Пролианс ХХК - ийн инженер |

**Хамрах хүрээ:**

Молекул биологийн лабораторитой 11 эрүүл мэндийн байгууллага

**Хугацаа:**

2021 оны 02 дугаар сарын 08-наас 23-ны өдрүүдэд